



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 08 сарын 07 өдөр

Дугаар АА/495

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Алтанбулаг сумын Мөнх-Өлзийт, Дорноговь аймгийн Сайхандулаан суман дахь радиолокаторын байгууламжуудын харуул, хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	М.Гүен	Аюулгүй байдал, хамгаалалтын албаны дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Санчир	Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Б.Гантулга	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Навигацийн хэсгийн Техник ашиглалтын тасгийн ахлагч инженер
	Ч.Алтанзүрх	Монголын Аэронавигацийн инженер техникийн ажилтнуудын холбооны гишүүн
	М.Эрдэнэсүх	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /М.Гүен/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Санчир/-д үүрэг болгосугай.

ДАРГА /  Л.БЯМБАСҮРЭН